



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/ЧНЧ

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.17 дах заалт, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Торгоны замын орнуудын “Хэм судлалын нийгэмлэг” хооронд 2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081738

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 09 сарын 26-ны өдрийн
А/... дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Реквава Ройн Rekvava Roin	Гүрж Улс	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Торгоны замын орнуудын “Хэм судлалын нийгэмлэг”	ГЭ0002453	Зүрх судлал	Эмчлэх	2019.10.07-2019.10.15 /9 хоног/